

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	8
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	11
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	20
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	20
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	26
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	29
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32
15. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд.....	3
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	11
Хүснэгт 3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	19
Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	24
Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт	26
Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	29
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	32
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй.....	33

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын зураг	3
Зураг 2. Ашиглалтын систем.....	4

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн нэр: “Зараа” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Анандбаян тал” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 9011141103, регистрийн дугаар: 5218624, албан ёсны хаяг: Баянзүрх, 14-р хороо, Консулын, 512 тоот, утас: 91912719/

Төслийн байршил: “Ананд баян тал” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын “Зараа” нэртэй хайлуур жоншны орд MV-017194 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь 94 га талбайг хамран оршино. Улаанбаатар хотоос 520 км Баруун-Урт хотоос зүүн тийш 20 км Сүхбаатар сумын төвөөс баруун тийш 35 км-т байрлана.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	113	29	32.24	46	39	14.73
2	113	29	32.25	46	39	41.75
3	113	28	39.24	46	39	41.75
4	113	28	39.24	46	39	14.73




Зураг 1. Төслийн байршлын зураг

Ордыг ашиглах тусгай зөвшөөрөл: Тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2012 оны 10 сарын 22-ний өдрийн тушаалаар MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Ананд баян тал” ХХК-д 2042 оны 10 сарын 22-ний өдрийг хүртэл олгосон байна.

Ашиглалтын систем: Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл, түүнчлэн ижил төстэй ордуудыг ашиглаж байгаа дэлхийн бусад улс орнуудын практик туршлага зэргийг үндэслэн Зараагийн хайлуур жоншны ордын ашиглалтад хамгийн тохиромжтой нь хүдэр хоршоолох ашиглалтын систем байна.

Хүдэр хоршоолох, шпурын цэнэгийн аргаар нураах ашиглалтын систем нь бага зузаантай босоо уналтай ордод хэрэглэхэд хамгийн тохиромжтой байдаг.

Хүдэр хоршоолох ашиглалтын систем хэрэглэх үед блок хоорондын хамгаалалтын цул, блоккийн дээд хамгаалалтын цул, штрекний дээд хамгаалалтын цулыг үлдээх бөгөөд хүдэр нураалтын ажлыг 1.2-1.4 м өндөртэй хэвтээ үеэр зохион байгуулна. Хүдэр хоршоолох ашиглалтын систем нь аваар осол багатайгаас гадна мөргөцгийн ажилчны хөдөлмөрийн бүтээмж өндөр, ашиглалтын хаягдал, бохирдол бага байдаг.



Зураг 2. Ашиглалтын систем

Уурхайн тээвэр: Зараагийн уурхайгаас гарах баяжмалыг нэгдүгээрт Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигтийн боомт хүртэл, хоёрдугаарт Сүхбаатар аймгийн Бор-Өндөр сум хүртэл авто, цаашаа Замын-Үүд боомт хүртэл төмөр замаар тээвэрлэх 2 хувилбараар тээвэрлэхээр төлөвлөсөн байна. Автотээврээр тээвэрлэхэд Бичигтийн боомт хүртэл 268 км, Бор-Өндөр хүртэл 360 км зайтай байна.

Ухаж ачих, тээвэрлэх процесс: Зараагийн орд нь 2014 онд олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд жоншны үнэ, хөрөнгө оруулалт зэргээс хамааран дийлэнх хугацаанд зогсонги байдалтай байсан. Одоогийн байдлаар зараагийн уурхайд 15кВ-ын дэд станц,

уурхайн тосгон, гүний худаг, далд уурхайн тоног төхөөрөмжүүд зэрэг шаардлагатай хөрөнгө оруулалтууд хийгдсэн, ашиглалтад бэлтгэгдсэн байна.

Дэд бүтэц: Зараа-6 орд нь Чингис хотоос 98 км, Сүхбаатар сумаас баруун зүгт 21 км-т орших бөгөөд ордын урд талаар УБ-Дорнод хүртэл хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг.

Уурхайн цахилгаан хангамж: Одоогоор уурхайд 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 250 кВА-н дэд станц суурилагдсан бөгөөд хүчин чадлыг өргөтгөж бүх хэрэглэгчдийг 0.4кВ-ын цахилгаан эрчим хүчээр тэжээх 10/0.4 кВ-ын нэг хүчний трансформатор бүхий 1,000 кВА-н дэд станц суурилуулахаар төлөвлөсөн байна..

Уурхайн усан хангамж:

- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 3.8 л/сек

Өрөмдлөг тэсэлгээний ажил: Тус орд нь судал хэлбэрийн, уналын өнцөг хайгуулын зүсэлтүүдээс үзэхэд 70-80°, агуулагч чулуулаг ба хүдрийн биетийн тогтворжилт нь тогтвортойгоос дунд зэрэг хүртэл, чулуулгийн хатуулаг нь проф.Протодьяконовын ангиллаар $f = 8-14$ байна. Уг үзүүлэлт мөнх хүдрийн биетийн зузаанаас харахад хүдрийг шпурэн цэнэгийн аргаар нураах, хүдэр хоршоолох ашиглалтын системийг сонгох таатай нөхцөл болж байна.

Малталт нэвтрэлт, хүдэр нураалтын ажилд хэрэглэгдэх өрмийн машиныг сонгохдоо далд уурхайн хүчин чадал, ашиглалтын систем, хүдрийн зузаан, чулуулгийн өрөмдөгдөх чанар, хатуулаг зэрэг үзүүлэлтүүдээс хамааруулан богино хугацаанд өндөр бүтээлтэй техник, тоног төхөөрөмж сонгох нь зайлшгүй шаардлагатай. Иймээс үндсэн болон бэлтгэл малталт нэвтрэлтийн ажилд болон хүдэр нураалтын ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн УТ-28 маркийн (перфератор) гар өрмийн машин хэрэглэхээр сонгосон болно. Энэхүү гар өрмийн машин нь босоо, хэвтээ, налуу малталтуудад болон нураалтад

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Сүхбаатар сум нь Монгол орны зүүн бүсэд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийн хойд хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос зүүн зүгт 520 км, аймгийн төв Баруун-Уртаас 20 км, Эрдэнэцагаан сумын нутагт орших хилийн Бичигт боомтоос 268 км-ийн зайтай оршдог. Мөн улсын хөгжлийн гол тэнхлэг-Мянганы замаас 141 км, бүсийн хөгжлийг тэтгэх босоо тэнхлэгээс 5 км-т /төлөвлөлтөд тусгагдсанаар/ тус тус оршдог. Сумын нутаг дэвсгэрийн баруун урд талаар Уулбаян, Халзан сумдуудтай, баруун талаараа Мөнххаан сум, хойд талаараа Дорнод аймгийн Булган, Хөлөнбуйр сумдуудтай, зүүн талаараа Дорнод аймгийн Матад, зүүн урд талаараа Эрдэнэцагаан сумтай, урд талаараа Асгат сумтай тус тус хиллэдэг.

Далайн түвшнээс дээш 1000-1500 м өргөгдсөн. Нутгийн ихэнх хэсэг нь хадлан тэжээл бэлтгэх, мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд нэн тохиромжтой зөөлөн хүрэн бор хөрстэй. Талбулаг, Дүнгэндэг зэрэг рашаан, ус, Бүрдэнэ говь, Их цагаан зэрэг хүнсний давсны нөөц арвинтай газрууд, барилгын төрөл бүрийн зориулалтаар ашиглах боломж бүхий шавар, зосны илэрц, Талбулаг, Салхит, Салаа, Арын нуур, Алтат, Төмөртэй, Тугалбулаг, Дөхөм зэрэг нүүрс өнгөт металлын судлагдсан ордтой.

Хөрс, хөрсөн бүрхэвч: Зараа” хайлуур жоншны орд байрлах Сүхбаатар сумын нутаг нь Төв Азийн их муж Хангайн дэд муж Монгол дорнодын тойрогт хамаарагддаг байна. Тус нутгийн хөрс нь делюви, элюви, аллювийн хурдас дээр үүсч тогтсон. Хүрэн хөрс нь ихэвчлэн делювийн хөвсгөр хурдас дээр, уулын хөрс нь элювийн хурдас дээр, голын хөндийн хөрс нь аллювийн жижиг бөөрөнхий хайрга чулуун дээр үүссэн.

Хар хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 2% ийг эзэлнэ. Дангаараа үргэлжилсэн бүс үүсгэж чадахгүй алаг цоог тархана. Энэ хөрсний ялзмагт үеийн зузаан нь дунджаар 32-38см-ын хооронд хэлбэлзэнэ. Карбонатын бөөгнөрөл 32-37см-ийн гүнээс ажиглагдана, хөрсний давхаргад гөлтгөнө огт байхгүй. Хар хүрэн хөрс нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Делювийн хурдас дээр үүсч тогтсон хар хүрэн хөрс нь дээд давхарга нь бараан хүрэн өнгөтэй, бөөмөнцөр бүтэцтэй, ялзмагт үе нь нэлээн зузаан, хөрсний давхарга нь нягтарч дагтаршсан хайрга чулуу харьцангуй бага, 45-50см-ийн гүнээс карбонатлаг бөөгнөрөл нь үгүй болно.

Хүрэн хөрс нь Сүхбаатар сумын 80% ийг эзэлнэ. Энэ хөрс нь ихэвчлэн долгиорхог тэгш тал газраар тархсан байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал: Гол тархах бүлгэмдэл нь Хялганат – хазаар өвс, Хялганат – агь, Хазаар өвст – хялгана - алаг өвс, Хялгана хиагт – алаг өвс, Үетэнт – хазаар өвс

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

эвшлүүд юм. Нам хотос, нарийн хөндийгөөр сийрэгдүү дэрс бүхий улалж – хиагт эвшил бас зонхилон ургадаг. Бяруутын район нь сумын нутгийн төв ба хойт хэсгүүдээр нэлээд их хэмжээний талбайг эзлэх бөгөөд ихэнх бэлчээр нь энд хамаарна. Зүүн хойт чиглэлд сунаж тогтсон нам хотос, хоолойнууд болон тэдгээрийн хооронд орших тэгш ба долгиорхог талууд өргөн уудам нутгийг хамарна. Хотос, хоолой нь маш аажмаар тэгш талруу шилжинэ. Энд алаг цоог, хужир мараат цагаан өнгийн шаварлаг толбууд болон жижиг тойрмууд элбэг тохиолдоно. Гол төлөв дэрс, зарим газраар Бударгана, Таана зонхилон Хиаг, Агь шарилж элбэг ургадаг. Сүхбаатар сумын нутагт Хялганат–хазаар өвст, жижиг үетэн–хялгана–агьт (шарилжит) Хялгана–сөөгт, Хялгана – хиагт, Хялгана – хиаг – алаг өвст, Хиаг - дэрст эвшлүүд тохиолдоно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникүүдийн шингэн түлшний шаталтаас ялгарах утаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчидын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эруул мэнд, хурээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн хүрээнд төлөвлөж буй далд уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бутцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн уйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бутээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл: Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах эрсдэлтэй байна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтадыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийг хэрэгжүүлэхд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2025 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.



Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг ажлууд багтсан байна.




5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Уурхайн тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед зам талбайн усалгаа хийх	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн зам талбайг тоосжилт ихтэй үеүдэд усалж чигшүүлэх арга хэмжээг авч ажилласан.	 <p>Усалгааг хийж гүйцэтгэсэн</p>
2	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн ачилт буулгалт, тээвэрлэлтийг тоосны сарнилтай уялдуудан төлөвлөж ажилласан.	 <p>Тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан</p>
3	Замын маршрутын дагуу хурдны тэмдэг тэмдэглэгээ тавих	Замын маршрутын дагуу хурдны тэмдэг тэмдэглэгээ тавих	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн орох хэсгийн хаягжуулалт, замын тэмдэг	

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

4		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, засвар үйлчилгээг тогтмол хийх	Бүрэн хэрэгжсэн	Тэмдэглэгээг зохих хэсгүүдэд байршуулсан. Авто тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оншлогоонд цаг тухайд нь үзүүлсэн.	
5		Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Бүрэн хэрэгжсэн	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.	 <p align="center">Тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулсан</p>
6		Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангаж ажиллах	Бүрэн хэрэгжсэн	Олобрлолтын талбайд ажиллаж буй ажиллагсад амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангаж ажилласан.	 <p align="center">Амны хаалт зэрэг хамгаалах хэрэгслээр хангасан</p>

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

7	<p>Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтгээх.</p>	<p>Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх</p>	<p>Бүрэн хэрэгжсэн</p>	<p>Машин механизмын засвар үйлчилгээг тусгай талбайд хийж гүйцэтгэсэн.</p>	
8	<p>Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>	<p>Хог хаягдлыг ангилан ялгах, битүү тагтай саванд хуримтлуулж тухай бүрт нь хогийн цэгт хаях</p>	<p>Бүрэн хэрэгжсэн</p>	<p>Хог хаягдал түр хадгалах цэгийг зориулалтын, нэвчилт үүсэхээргүй байхаар засаж сайжруулсан.</p>	

Ахуйн хог хаягдал түр хадгалах цэг

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

9		ШТМ-ын стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Бүрэн хэрэгжсэн	Шатах тослох материалыг сум, орон нутгаас техник хэрэгсэлдээ дүүргэж ирдэг ба шаардлагатай үеүдэд ШТМ хадгалах машинд хадгалж байна.	
10		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн нийт жолооч операторууд болон ажиллагсдад байгаль орчныг хамгаалах сургалтыг зохион байгуулсан.	 <p align="center">Байгаль орчны сургалт зохион байгуулсан</p>



Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жонинны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

11	<p>Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.</p>	<p>Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх</p>	<p>Бүрэн хэрэгжсэн</p>	<p>Ус ашиглалтын гэрээг Сүхбаатар аймгийн Байгаль орчны газартай 2025 оны 10 сарын 01-ний өдөр хийсэн. Ус ашиглах зөвшөөрлийг 2025 оны 10 сарын 01-ний өдрийн А/42 тоот тушаалаар гаргуулсан. Хаягдал усны дүгнэлтийг Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газраас E-2510-000325 дугаартай дүгнэлтийг гаргуулсан. /Ус ашиглалтын гэрээ, Ус ашиглах зөвшөөрөл, Хаягдал усны дүгнэлтийг хавсаргав./</p>	<p align="center">Ус ашиглалтын гэрээ</p> <p align="center">Ус ашиглах зөвшөөрөл</p>
----	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------	------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------


Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

					<div data-bbox="1523 186 1971 813"> </div> <p style="text-align: center;">Хаягдал усны дүгнэлт</p> <div data-bbox="1433 845 2072 1316"> </div> <p style="text-align: center;">Усны төлбөр төлсөн</p>
--	--	--	--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

12		Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00 ийн ариутгал халдваргүйжүүлэлт	Бүрэн хэрэгжсэн	Ажилчдын байр, 00, хогийн цэгийн орчмын ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.	 <p>Ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн</p>
13	Авто машины зогсоол, засварын цех	Осол гарч болзошгүй мал, амьтан өнгөрөн гардаг хэсгүүдэд тэмдэглэгээ байрлуулах	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн талбайд шаардлагатай тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан.	 <p>Тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан</p>
14	Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад	Бүрэн хэрэгжсэн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх талаар ажилчдад сургалт хийж, өдөр тутмын хог хаягдал ил задгай хаягдахаас сэргийлж	

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

		үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх		төслийн талбайд тогтмол хяналт шалгалт, заавар зөвлөгөөг өгч, хог хаягдлыг тогтмол цэвэрлэсэн.	
15	Амьтанд гэмтэл учруулах, тоо толгой хорогдох	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	Бүрэн хэрэгжсэн	Нийт ажиллагсдад байгаль орчин, ХАБЭА-н сургалтанд хамруулсан.	




Сургалт зохион байгуулсан

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Зараа” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах бөгөөд эвдрэлд өртөх талбай бага учир 2025 оны техникийн нөхөн сэргээлтийн ажлыг сум орон нутгаас санал авсны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийднэ.

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Орон нутгаас авсан саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх /Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 50 ш мод тарих/	бүрэн хэрэгжсэн	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн баруун урд талд 50 ш мод тарьсан.	   <p>Дүйцүүлэн хамгаалах ажлаар тарьсан моднууд</p>

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Анандбаян тал” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд палеонтлогийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.



10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол,сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	бүрэн хэрэгжсэн	Ажилчдад осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, осол эрсдэлийн үед авах арга хэмжээний заавар зөвлөгөөг өгч, сургалтыг зохион байгуулсан.	 <p data-bbox="1429 1066 2101 1129">Ажилчдад осол эрсдэлээс сэргийлэх сургалтыг зохион байгуулсан</p>


2		<p>Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох / Гал унтраах багаж хэрэгсэл, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт /</p>	<p>бүрэн хэрэгжсэн</p>	<p>Галын сараа, элс, галын хор зэрэг болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгслүүдийг шаардлагатай газруудад байршуулсан.</p>	 <p>Галын сараа, галын хор, элс зэрэг шаардлагатай зүйлсийг байршуулсан</p>
---	--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан



3		<p>Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж ХЭВШИХ</p>	<p>бүрэн хэрэгжсэн</p>	<p>Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, засвар үйлчилгээнд тогтмол оруулсан.</p>	
4		<p>Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд 1 удаа зохион байгуулах</p>	<p>бүрэн хэрэгжсэн</p>	<p>Байгаль орчныг хамгаалах сургалтыг зохион байгуулсан</p>	 <p align="center">Байгаль орчныг хамгаалах сургалтыг зохион байгуулсан</p>

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт




№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	бүрэн хэрэгжсэн	Хог хаягдлыг 2025 оны 10 сарын 28-ний өдөр Сүхбаатар сумын ЗД-тай хог хаягдлын гэрээ байгуулсан. Гэрээний дагуу хог хаягдлыг тогтмол тээвэрлүүлсэн. /Хог хаягдлын гэрээг хавсралтаар оруулав./	 <p>Хог хаягдлын гэрээ</p>
2		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	бүрэн хэрэгжсэн	Хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын шаардлага хангах, хөрс	

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

				бохирдохоос сэргийлж доторлогоог хийж гүйцэтгэсэн.	
3		Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	бүрэн хэрэгжсэн	Ахуйн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх талаар сургалтыг зохион байгуулж, хаягдлын цэгийг доторлосон.	 <p align="center">Ахуйн хог хаягдал түр хадгалах цэг</p>
4		Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	бүрэн хэрэгжсэн	Ажилчдын байр, 00, хогийн цэгийн орчмын ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.	 <p align="center">Ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн</p>
5		Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй тохижуулах	бүрэн хэрэгжсэн	Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх талаар ажилласдад өдөр тутмын зөвөлгөө, санамжийг өгч ажилласан.	




12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт

№	Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
Хөрсний шинжилгээ					
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Төслийн талбайн 2-3 цэгт	Бүрэн хэрэгжсэн	Хөрсний агрохими, механик бүрэлдэхүүний дээжийг 2025 оны 10 сарын 06-ний өдөр уурхайн олборлолтын талбай, засварын талбай орчим, ажилчдын кемпийн орчимд 3 цэгт хөрсний зүсэлт хийж дээж авч хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	
2	Хүнд металлын агууламж	Төслийн талбайн 2-3 цэгт	Бүрэн хэрэгжсэн	Хөрсний хүнд металлын дээжийг 2025 оны 10 сарын 06-ний өдөр уурхайн олборлолтын талбай, засварын талбай орчим, ажилчдын кемпийн орчимд 3 цэгт хөрсний зүсэлт хийж хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	
3	Хөрсний эрүүл ахуй	Төслийн талбайн 2-3 цэгт	Бүрэн хэрэгжсэн	Хөрсний эрүүл ахуйн дээжийг 2025 оны 10 сарын 06-ний өдөр уурхайн	



Хөрсний дээжлэлт хийх үеийн зураг

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жонинь ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан



					<div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="width: 45%;">  </div> <div style="width: 45%;">  </div> </div> <p align="center">Хөрсний агрохими, хүнд металл, эрүүл ахуйн шинжилгээний дүнгүүд</p>
Усны хяналт шинжилгээ					
4	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	Бүрэн хэрэгжсэн	Уурхайн ажилчдын унд ахуйн усаа хангаж буй худгаас 2025 оны 10 сарын 06-ний өдөр усны шинжилгээг авч усны итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	 <p align="center">Унд ахуйн усны шинжилгээний дүн</p>


13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт	Тайлбар	Гүйцэтгэл
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	бүрэн хэрэгжсэн	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаандаа дотоод журмыг гарган мөрдөн ажиллаж байна.	 <p>“АНАНД БАЯАН ТАЛ” ХХК БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ДОТООД ЖУРАМ</p> <p>– Засгийн газрын 2011оны 311 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн заалт – Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2</p> <p>2025 он</p> <p>Байгууллагын үүрэг хариуцлагын дотоод журам</p>
2	Осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, зохион байгуулах	бүрэн хэрэгжсэн	Нийт ажиллагсдыг ХАБЭА болон осол эрсдэлийн үед авах арга хэмжээ, ослоос урьдчилан хэрхэн урьдчилан сэргийлэх тухай сургалтанд хамруулсан.	 <p>Ажилчдад осол эрсдэлээс сэргийлэх сургалтыг зохион байгуулсан</p>

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

3	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ-д хүргэн өгч байх	бүрэн хэрэгжсэн	2025 оны БОМТ-ийн биелэлтийн тайланг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 11 дүгээр сарын 01-ний дотор хүлээлгэн өгч ажиллаж байна.ажилчдад зохион байгуулсан.	
4	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	бүрэн хэрэгжсэн	ХАБЭА-н нөхцөлийг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгасан тухай, зааварчилгааг өгч, бүртгэл хөтөлж ажилласан.	
5	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	бүрэн хэрэгжсэн	ХАБЭА-н үзлэг шалгалтыг байнгын хийсэн.	
6	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	бүрэн хэрэгжсэн	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангаж ажилласан.	<p align="center">ХАБЭА-н өдөр тутмын зааварчилгааны дэвтэр</p>  <p align="center">Ажилчдыг шаардлагатай хувцас, хэрэгсэл, малгай, амны хаалтаар хангаж ажилласан</p>

7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	бүрэн хэрэгжсэн	Яаралтай анхан шатны тусламж, шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлийг байнгын бэлэн байлгаж ажиллаж байна.	 <p>Яаралтай анхан шатны эм тариа, багаж хэрэгсэл</p>
---	----------------------------------------------------------------------------------	-----------------	-------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ, БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Тайлбар
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумын засаг захиргаанд хүргүүлнэ	БОМТ-ний биелэлт	2025 оны БОМТ-ийн биелэлтийн тайланг боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 11 дүгээр сарын 01-ний дотор хүлээлгэн өгч ажиллаж байна.

15. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

“Ананд баян тал” ХХК нь жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний хүрээнд хүрээлэн буй орчныг сөрөг нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг тус тус төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн ба доорх хүснэгтэд эдгээр үйл ажиллагаанд шаардагдах зардал, зарцуулсан төсвийн хураангуйг үзүүлэв. 2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 21.0 сая төгрөг зарцуулав.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Арга хэмжээ	БОМТ нийт төсөвлөсөн зардал төг /сая.төг/	Төсвийн гүйцэтгэл зардал /сая.төг/	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	10.0	6.5	Зам талбайн усалгаа хийх, тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, тэмдэг тэмдэглэгээ байршуулах зэрэг зардлууд багтсан.
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	-	-	Тухайн жилийн БОМТ-д заагдсаны дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийдвэрлэсэн.
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	2.0	5.0	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын төвийн баруун урд талд 50 ш мод тарьсан.
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.1	5.0	Аюул ослоос урьдчилан сэргийлэх багаж хэрэгслийг бэлэн байлгах, дахин худалдан авах, ажилчдыг нэг бүрийн хэрэгслээр хангах зардлууд багтсан.
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2.41	3.0	Хог хаягдлын ачиж зайлуулах төлбөр, хог хаягдлын түр хадгалах цэгийг сайжруулах, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардлууд шийдэгдсэн.
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.5	0.5	Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хөрс усны шинжилгээг хийлгэж “Ланд овнер” ХХК-ийн Грийн лаб хөрс, усны итгэмжлэгдсэн лаборатори”-д шинжлүүлсэн.
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1.0	1.0	Яаралтай анхан шатны эм тариа, хэрэгсэл худалдан авах, БО, ХАБАЭ-н сургалтууд зохион байгуулах зэрэг зардлууд багтсан.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах “Анандбаян тал” ХХК-ийн MV-017194 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зараа” хайлуур жоншны ордын газрын 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайлан

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	20.01	21.0	
----------------------------------------------------------------------	--------------	-------------	--



СҮХБААТАР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/ЧД

Баруун-Урт сум

